



**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2011 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 490


Улаанбаатар хот

Журам батлах тухай


МУИС-ийн дүрмийн 2.1, 3.2, 8.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж сайшаагдсан "МУИС-д эрдэм шинжилгээний ажилтан ажиллуулах журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Хамтын ажиллагааны гэрээ байгуулах тухай журам"-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

ЗАХИРАЛ



Д-р, Проф. С.ТӨМӨР-ОЧИР



Захирлын 2011 оны 9 сарын 27-ны өдрийн 4-р тоот тушаалын хавсралт 2


ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ТУХАЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын Их Сургууль /цаашид МУИС гэх/-ийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, гадаад харилцааг бүс нутагт зорилтод үйл ажиллагаагаар хөгжүүлэх, МУИС-ийн 2020 он хүртэлх стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.
2. Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал МУИС-ийн захирал шийдвэр гаргана.

Хоёр. Гэрээ байгуулах санал ирүүлэх, шийдвэр гаргах

3. Доор дурьдсан байгууллага, багш ажилтан, албан тушаалтнууд хамтын ажиллагааны гэрээ байгуулах санал болон сонирхолоо илэрхийлж болно. Үүнд:
 - МУИС-ийн үндсэн болон бүтцийн нэгж
 - МУИС-ийн удирдлага
 - Гэрээ байгуулах сонирхолоо илэрхийлсэн аль нэг улс орны их дээд сургууль, институт, гадаад, дотоодын байгууллага
- 3.1. Гадаад, дотоодын байгууллагаас ирсэн саналыг Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс (ГХХАХ) тухайн байгууллагын товч танилцуулга болон гэрээ байгуулах үндэслэл, хүлээгдэж буй үр дүнгийн талаарх товч илтгэлийг бэлтгэн Захиргааны зөвлөлд оруулж хэлэлцүүлнэ.
- 3.2. Захиргааны зөвлөлөөс МУИС-ийн нэрийн өмнөөс байгуулах шаардлагагүй гэрээ гэж үзвэл холбоо хамааралтай аль нэг бүрэлдэхүүн сургуульд шилжүүлж болно.
- 3.3. Бүрэлдэхүүн ба салбар сургуулиуд гэрээ байгуулах санал гаргах тохиолдолд уг гэрээг байгуулах үндэслэл, сургуулийн товч танилцуулга, хүлээгдэж буй үр дүнгийн талаарх товч илтгэлийг бэлтгэн ГХХАХ-т ирүүлэх бөгөөд уг гэрээг байгуулах үндэслэлтэй гэж үзвэл ГХХАХ-ээс 30 хоногийн дотор Захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.
- 3.4. МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын 2-3-тай нь факультет хоорондын гэрээтэй гадаад, дотоодын байгууллага, их дээд сургуультай МУИС-ийн нэрийн өмнөөс хамтын ажиллагааны гэрээг байгуулж болно.



Гурав. Гэрээнд гарын үсэг зурах, баталгаажуулах, архивлах

- 4. Гэрээний төсөл, танилцуулга, үндэслэл үр дүнгийн тухай товч илтгэлийг Захиргааны зөвлөлөөр хэлэлцэн гарын үсэг зурах шийдвэрийг Захиргааны зөвлөл гаргана. МУИС-ийн захирал эсвэл орлох албан тушаалтнууд гэрээнд гарын үсэг зурна.
- 5. Шаардлагатай тохиолдолд гэрээнд хариуцах этгээдийг /liaison officer/ томилно.
- 6. Гэрээг шуудангаар солилцож зурах эсвэл гарын үсэг зурах ёслолын арга хэмжээг зохион байгуулах хэлбэрээр байгуулж, баталгаажуулна.
- 7. Баталгаажсан гэрээ эх хувиараа ГХХАХ-т хадгалагдах ба гэрээний цахим архивт ажлын 7 хоногийн дотор орсон байна.
- 8. Бүрэлдэхүүн болон салбар сургуулиуд гадаадын их дээд сургуультай гэрээ байгуулах тохиолдолд тухайн бүрэлдэхүүн ба салбар сургуулийн эрдмийн зөвлөл эсвэл захирлын зөвлөлөөс шийдвэр гаргаж гэрээг баталгаажуулна.
- 9. Бүрэлдэхүүн ба салбар сургуулиуд гарын үсэг зурж баталгаажсан гэрээг эх хувиар нь хадгалах ба гэрээг ГХХАХ-т цахим хэлбэрээр ирүүлж, цахим архивт бүртгүүлнэ.

Дөрөв. Гэрээг сунгах, дуусгавар болгох

- 10. Гадаадын их дээд сургуулиас ирүүлсэн хамтын ажиллагааны гэрээг сунгах, дуусгавар болгох саналыг Захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.
- 11. Гэрээний үр дүнгийн тухай тайлан болон цаашид үргэлжлүүлэн сунгах эсвэл дуусгавар болгох үндэслэлийг бичиж Захиргааны зөвлөлийн хуралд оруулж хэлэлцүүлнэ.
- 12. Шийдвэрийг үндэслэн ГХХАХ-ээс тухайн санал ирүүлсэн гадаадын их дээд сургуульд бичгээр хариу мэдэгдэнэ.